

**ДАРБА БАНДИДА ГЭГЭЭНТЭН ХИЙГЭЭД “АРД ТҮМНИЙ АРИУН ЁС ОРШИВ”
БҮТЭЭЛИЙН ТУХАЙД ӨЧҮҮХНИЙГ НЭМЭРЛЭХҮЙ**

А.Пүрэвжанцан

Хураангуй: Халхын Сайн ноён хан аймгийн Мэргэн гүний хошуу (Архангай аймгийн Цэцэрлэг, Хөвсгөл аймгийн Рашаант) одоогийн Архангай аймгийн Цэцэрлэг сумын харьяат Монголын бурхан шашны эрдэм төгөлдөр гэгээнтэн Агваанчойжирдондовын унасан газар, угаасан ус, нялх балчрынх нь дурсамж, гэгээнтэнд тодрох үеийн өвөө, хүүгийн яриа, бандид хэмээх цол хэргэмийн тухай улмаар төрсөн нутгийнх нь түмэн олон түүний лагшин мэндэлсний 135 жилийн ойгоор гэгээнтний эснэсэн газарт “Лянхуа цогцолсон суварга” босгосон хийгээд одоогоос 100 жилийн өмнө 53 насан дээрээ зохиосон “Ард түмний ариун ёс оршвой” зохиолд бидний эдүгээ ч ярьдаг ардач үзэл, олон ургалч санаа агуулсны хувьд эргэцүүлэн бодууштай зүйл бишгүй байх агаад төр улсын гадаад дотоод бодлого, удирдах ажилтан сэхээтэн хүнд санаа сэдэл болох олон зүйлийг эш болгон өгүүлснээс товчлон буулгаж олны хүртээл болгохыг эрмэлзэв.

Түлхүүр үг: *гэгээнтэн, эрдэмтэн, номтон, багштан, оюунтан*

БАНДИДА: Дорно дахины дуун ухаан, учир шалгадаг ухаан, урлахуй ухаан, дотоод ухаан /бурхны сургаал/, тэжээхүй ухаан хэмээх их таван ухаан хийгээд зурхай, зохист аялгуу, ил ёгт өгүүлэхүй, холбон найруулахуй, жүжиглэхүй хэмээх бага таван ухаанд нэвтэрсэн эрдэмтэнд олгодог энгүй дээд эрхэм цол юм байна. Одоо мэдэгдэж буйгаар Монголчуудын дунд бүр XIII зууны үеэс хэлний зүйч Чойжи-Одсэр, XVI зууны үеэс Цаст Төвөдийн оронд хүрч хүртсэн Ойрадын Зая бандида Намхайжамц /1599-1662/, Халхын Ламын гэгээн Лувсанданзанжалцан /1639-1704/, Зая бандида Лувсанпэрэнлэй /1642-1775/, Сүмбэхамба Ишбалжир /1704-1788/, Ишбалдан бандида /XVIII/ зуун, Тарган бандида Цэвэлванчиндорж, Тарба бандида Дагбажалцан зэрэг хүмүүс бол Дорно дахины их бага ухааны аймагт тэгш нэвтэрсэн аугаа мэргэд байжээ.

Дарба Бандида гэгээнтэн Агваанчойжирдондов

Түүний нэг Да хүрээний гавж, аграмба, Дарба банди хувилгаан, гэгээн Агваанчойжирдондов Бүрэн Засагчийн есдүгээр онд /1870/ дээр өгүүлсэнчлэн эдүгээгийн Архангай аймгийн Цэцэрлэг сумын Чулуут багийн нутаг “Номтын эх” хэмээх газар хошууны ард Насангийн гэрт мэндэлжээ. Угийн нэр нь Дамдинсүрэн. Их бичгийн хүн хэмээн алдар нэр нь түгсэн энэ эрхэм Энэтхэг, Төвөдөд бурханчлан тахигдаж байсан том лам Дарба хувилгааны хойд дүрээр 5 насандаа тодорчээ. Тэрээр 3 настайдаа өвөөтэйгөө айлаар тараг өрөм эргүүлж явахдаа “Өвөө намайг Дарба бандида гээч” гэж хэлэхэд өвөө нь сандран мэгдэж “Тал амсмар, алдас болно. Чи бид хоёр тийм том хүний нэрийг авч яаж болох вэ” гэсэн гэдэг. Мөн хүүг 5 настайд нь гэгээнтний дүрд тодруулахаар тэдний очиход өвгөн ихэд сандран “Та нар айл андуурсан болов уу. Суулгах гэхээр ширдэг байхгүй, амсуулах гэхээр идээ байхгүй айлын ийм өтөг шороотой холилдсон хүүхэд яаж гэгээнтэн байх вэ” гэжээ. Гэтэл хүү хүмүүсийн авчирсан хувцсыг хараад

“Энэ миний хувцас мөн байна. Харин та нар эрхийг минь мартсан байна” гэж сандаргажээ.

Дамдинсүрэн бээр Гунгаа Чойжин, Амдуу нарын аймагт шавилан сууж, Чойрын 5 боть ном үзэж өөрөө нэг боть ном бичжээ. Тэрээр 36 насандаа Гавжийн дамжаа барьсан. 1904 онд VIII Далай ламыг дагаж ирсэн лам нар, монгол лам нартай ном хаялцан бандида цол хүртээд зогсохгүй “Эрдэм номыг сурахад сайтар шамдав” хэмээн Далай ламаас “Эрдэнэ сайн ерөөлт” цол дүгрэг, дөрвөлжин тэмдэг бас нэмж Номч мэргэн хамбо бандида цол хүртээжээ. 1918 онд Богдын зарлигаар Данжуурын бар сийлэх ажлыг хариуцан гурван жилийн турш эхний 11 ботийн барыг сийлүүлжээ. Засгийн газрын Ерөнхий сайд Жалханз хутагт таалал болоход түүний орны хүнийг сонгох талаар Төв хорооны тэргүүлэгч Ринчиновыг Москвад явж байхад нь цахилгаан утсаар санал асуухад “Ерөнхий сайдад Дарба бандида буюу Манзүшри лам зэрэг хүмүүсээс тохоовоос сайн” хэмээн хариулж байсныг үзэхүл ерөнхий сайд болох хэмжээний их хүмүүн байжээ.

Мөн түүнийг Шинэ Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнд урьж залахаар эрдэмтэн Цэвээн нарын хүмүүс очиход “Жалгынхаа хуралд очиж эс чадах хөгшин лам би юугаа хийхэв. Харин ардын засгийн бодлогод нийцвэл үүнийг тунгаана уу” хэмээн “Ард түмний ариун ёсон оршив” хэмээн номоо өгөхдөө “Та бүхний эрдэм номын үйлсэд нэмэр оруулж чадах нэгэн хүн явуулъя” хэмээсэн нь Мэргэн гүн Гомбожав болой. Ийнхүү эрдэм билэг төгс гэгээнтэн 1921 оны Ардын хувьсгалыг таалан дотночлон, аядуу тайвнаар хүлээж, өөрийн тааллаар Идэр, Чулуутын голын бэлчир орчим жижиг гэр барин аж төрж дээрх бүтээлээ туурвин суужээ.

Ариун номын хувилгаан, гавж, аграмба, Монголын бурхан шашны эрдэм төгөлдөр гэгээнтэн, шашныг шинэтгэгч үзлийг залгамжлагч VI Дарба Бандида Агваанчойжирдондов 1927 онд 57 насандаа жанч халжээ. Энэ хүний лагшин мэндэлсний 135 жилийн ойг тохиолдуулан 2005 онд Идэр, Чулуутын бэлчир нутаг “Номтын дэвсэг” хэмээх газар “Лянхуа цогцолсон цагаан суварга”-ыг тухайн үеийн Цэцэрлэг сумын Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөлийн дарга, МУ-ын хөдөлмөрийн баатар, Сансрын нисэгч, ШУ-ны гавьяат зүтгэлтэн М.Ганзоригийн санаачилга, удирдлагын дор бум түмэн, бурхны олон шавь нар нь бие, хэл, сэтгэлээрээ цогцлоон бүтээсэн нь авшиг ном, ариун буяныг даллан сүндэрлэсээр байнам.

Мөнхүү бурхан багшийн 16 архадын нэг Лампармын хойд дүрийг 16 удаа тодруулснаас долоо нь Монголд мэндэлжээ. Монголд тодорсон анхны дүрийг Дарба бандида гэгээнтэн хэмээн өргөмжилсөн юм ажээ. Гэгээнтний анхдугаар дүр 1637 онд Монголд мэндэлснээс хойш 7 дахь дүрээр өдгөө 2013 онд Хөвсгөл аймгийн Рашаант суманд мэндэлсэн монгол хүүг тодруулсан. Бандида гэгээнтэний долдугаар дүрийн хувилгаан номын нэр нь Данзанчойжийлодой бөлгөө.

“Ард түмний ариун ёсон оршвой” шастир

Энэхүү бүтээлийг /1923/ эхэд нь өөрөө шастир гэж бичжээ. Эл зохиол туурвиснаас хойш эдүгээ 100 жил болжээ. Мэргэн хүмүүний өгүүлснээр шастирт “...одоо цагийн хүмүүсийн аж төрөл, төр засгийн хэргийг хэрхэн удирдаж явуулбаас зохих, бүгд зөвлөх засаг буюу Бүгд найрамдах засгийн ач тус, шашин төрийн харьцаа ба эртний хос ёсны тухай, эрдэм номын ач тус, ихэс дээдэс, эгэл олны холбоо харилцаа ямар байвал зохилтой...” тухай үзэл бодлоо илэрхийлсэн. Тухайлбал:

Ашдын сайн мөрийг олгогч
Аяа хуурмаггүй гурванаа мөргөмүй
Ард бүхэн хэн тэгш жаргахын
Амгалант журам батлуулан өршөө

Анхан улс төр байгуулсны хэрэг нь: Харьат олон ардыг боолчилж, нэгэн хэдэн

ихсийн тусыг бүтээсүгэй хэмээсэн нь огт бус, нийт олон ард түмний тусыг алагчлахгүй хичээн бүтээж, ард түмнийг аливаа зүдгүүр зовлонгоос энх түвшнээр хүмүүжүүлэн жаргуулахын тулд улс төр байгуулсан болохын дээр улс төрийн эрхэм хэрэгтэй зүйл нь ёслол, журам, цэвэр, ичимтгий хэмээгч улсын дөрвөн баримт бадрахгүй болбоос улс даруй мөхнө.

Энэ хэдэн зүйл нь улсыг тогтноулах чухал хэрэг мөний тул үүнийг манай халх монголын байдал дээр өгүүлбээс: ... саяхны арваад жилийн өмнөөс манай халх өөртөө эзэрхэх улс болсон хэмээвч гэгээн засгийн явдлыг зөвхөн шүүмжилж, осол залхай муу самуун суртлыг залруулан устгаж явуулахыг эрхлэх ба дотоод засгийн байдлыг ариун шударгаар явуулах, олон амьтан амар тайван, түвшин дөлгөөн болсон ч зарим сайд ноёд, лам нар нь урьдын муу сурамгай эзэрхгийг халсангүй хэвээр амташлыг олж, шударгыг устгаж, зусар бялдуучийг үхширтэл баримтлан... хэзээд завшихыг бодон өнгө мөнгө үлэмжтэнийг өршөөн асрах, ядуу буурайнуудыг огт орхих, зусар бялдуучийн засварласан гоёч үгийг сонсох мөртөө гэртээ суугчдыг цаазлах ба бурхны сургаал, тэнгэрийн ёс, улсын хууль, үйлийн үр тэргүүтэн лүгээ харшлах хэргийг өдөр бүр олонтоо шийтгэн бүхийг илхэн мэдсээр, юуны учирт бүгд зөвлөх засгийг хүсэхгүй билээ. Завшаанд зөвлөх засагтай болж ардын намын эрхтэй гэгээн засгийг нээсэн нь чухамхүү бодвоос нуурын усан хатаж шавардсаны доторх загас мэлхий хурын усан лугаа учрах мэт болжээ.

Бас нэгэн зүйл ардын намын ёсон болбоос бурхны ёсонд чухам нийцэх учир нь юун хэмээвээс Бодисадын аймаг савын номоос өгүүлбээс: Хүн өөрийн амин завшааныг бодолгүй ямагт бусдын тусыг бодвоос чухам хүн болсны хэргийг бүтээсэн мөн хэмээн номлосныг гол үндэс болгожээ. Бурхан багш бээр урьд бурхан амьтны тусад бурхны хутгийг олохын тухай өөрийн нүд, толгой, бие, эд тэргүүтнийг өглөг болгон үйлдэж байсан учруудыг санавал ямагт бусдад тусыг үйлдвэл сайн болох нь илхэн бөгөөд ертөнцөд төрсөн аливаа хүн төрөлхийн сайнгүй нь үгүй. Зарим нэгэн сайнгүй нь цөм дотоодод бол хүсэл дуршилд халхлагдах ба гадаадад бол муу сурталд халдварлагдсаны тул уг сэтгэлийг сахин чадахгүйн тулд тэнгэрийг сөржээ. Ингээд хүний сэтгэлд агуулсан хэргийг ялах нь адил тул тийнхүү дээд тэнгэр толилон үзэж зовлон буяныг буулгана. Буяныг буулгасан нь: тусгайлан сайн хүнийг илэрхийлэн өршөөх нь буюу. Зовлон буулгах нь мөн доорд иргэнийг тодорхойгоор цээрлүүлж эндэгдлийг халж сайнд шилжтүгэй хэмээх нь буюу хэмээсэн буй.

Бас нэгэн зүйл урьдын мэргэн түшмэдийн өгүүлсэн нь: Түшмэл та бүгд хууль цаазыг гууль болгон өнгө мөнгөөр ялыг бүү талла гэсэн ба шударга журамтайгаар улсад зүтгэ, хэрэв бүр авлигач болон олныг гасалгах бол миний хүүрийн хүрээнд бүү ор хэмээн үр ач шавь нарт сургасан мэт. Аливаа улс төрийг тэтгэгч олон ардыг эрхэм, доод хэмээн ялгаварлахгүй цөм нэгэн адил шударгыг гол болгон үзэж, ард түмний хөрөнгө амьдралыг хэмнэхийг урьдал болгон аливаа гарлагатай зарлагыг хасаж, олны зовлон зүдгүүрийг тэгшлэх ба ард түмний асрах нигүүлсэхийг гол болгосон шударга ариун хэмээхийг бат нот агуулсан түшмэл нь улс төрд онц их эрдэнэ буй за хэмээжээ.

Бас өгүүлсэн нь: Сайныг хураах гэрт удтал баяр буй. Мууг хураах гэрт удтал гамшиг буй. Гагцхүү дээд сайн нь үүрд үгүй. Сайн явбаас юун буян хүргүүлнэ. Муу явбаас юун гамшиг хүргүүлнэ. Сайн хүн сайнтай явж өдөр бүр ханахгүй. Муу хүн сайнгүй явж мөн өдөр бүр ханахгүй. Бага сайныг буян болохгүй гэж бүү хөнгөл. Өчүүхэн муу хурснаар бие сөнөхөд хүрч одно хэмээсэн мэт.

Их ноёд найр цэнгэл, гоёл заслыг эрхэмлэн улс төрийн бодлогыг мартсанаар сайнгүй болжээ хэмээн өгүүлсэн нь: Бичиг эрдмийг хичээнгүйлэн сурвал дотрын харанхуй арилан гэгээн ухаант болон өөрийн биеийг засаж түүнээс гэрийг засаж түүнээс дэвшин улс төрийг засахад хүрдэг тул эрдэм сурахыг эрхэм болгон энэхүү бүгд зөвлөх засгийн сургуульд оролцвол нимгэнийг халж шударгаар давшин, гажууг тэвчиж төв болох хэмээжээ.

Бас өгүүлрүүн: Сайныг үзсэнд ундаасах мэт бологтун! Мууг сонсоод дүлий мэт бологтун! Эрдэм төгөлдөр мэргэдийг шүт! Эрдмээр мөхөс эрэгтэй хүнийг тэвч! Язгуур эрхээр оморхсон хүнийг хор мэт үз! Усгал шударга нөхрийг уух эм мэт шүт! хэмээн бошиглон зарлигджээ.

Ариун ёсон үүнийг тогтоовоос
Ард бүхэн амгаланг эдэлтүгэй хэмээн
Асар хиргүй саналаар
Алдаршсан нэр бандида хэмээх бичив.

Дүгнэлт

Ар халхын номч мэргэн, Дарба бандида гэгээнтэн Агваанчойжирдондов нялх балчир ахуйдаа ядуу ардын тарчиг татуу амьдралд төрж өсөн, өөрийн эх болоод өвгөн эцгийн гараас хөтлөн элдвийг хүүрнэн торнисоор бурхны мэлмийд торон тодорч, гэгээнтний их хувь тавиланг хүртжээ.

Мөн тэрээр “Ард түмний ариун ёс оршив” зохиолдоо түмэн олон эв найртай, хүчийг нэгтгэн сайхан амьдрах, засаг ноёд чигч шударгуу байж, худал хуурмаг, хулгай дээрэм, булхай бузрыг тэвчсэн, удирдах удирдуулах ёс ямар байх, шинэ тутам байгуулагдаж буй ардын төрийн үйл хэргийг хэрхэн хөтөлбөл зохилтой зэрэг өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй сургаал айлтгалыг туурвисан байна.

Abstract

The wise Agvaanchoijirdondov Saint Darba Bandida of Ar Khalka was born in a poor family, in his early age lived with his mother and grandfather, later he received an extraordinary destiny of a Saint.

In his work named “Sacred culture of folks” he wrote about living in peace and harmony, the authorities should be trustworthy and avoid lies and stealing, rules of governing, and how to lead the newly established people’s state. These great preachings are still valuable even today.

Жич: Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгээс олноо өргөгдсөний арван гуравдугаар онд дээрх шастирыг нийслэл хүрээн дэх орос, монгол хэвлэлийн газар дармаллан 3000 хувь гаргажээ. “1963-1965 оны үед Лувсандорж ах надад өгсөн юм. Хуучин бичгээс өөрөө кирилл бичигт буулгасан болов уу. Тэр үед ах маань Архангай аймгийн сурганы кабинетад ажилладаг байлаа” хэмээн түүний төрсөн дүү ШУТИС-ийн ахмад багш, МУ-ын гавьяат багш Ж.Гэрэлхүү хуучлан дамжуулснаас эшлэн ашиглав.

Ном зүй

Ард түмний ариун ёсон оршив. 1923. Улаанбаатар.

Ганзориг М. 2005. *Дарба бандида гэгээнтэний 17-р дүр Агваанчойжирдондов.* Улаанбаатар.

Дашбадрах Д. 1991. *Ард түмний ариун ёсон оршивой.* “Үнэн” сонин. № 137. Улаанбаатар.

Монгол улсын үндэсний нэвтэрхий толь. I. II. III боть. 2009. Улаанбаатар.

МОНЦАМЭ МЭДЭЭ. 2004. № 207. Улаанбаатар.

Пүрэвжанцан А. 2016. *Арын номин хангайн хоймор сайхан нутаг.* Улаанбаатар. 24-25-р хуудас

Пүрэвжанцан А. 2012. *Зуун жилийн түүхт Бухын хүрээ.* Улаанбаатар.